



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 28/03

Арвайхээр сум

Аймгийн Хүүхэд хамгааллын бодлогын талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.15 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3.3-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг 46,7 хувь буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үзсүгэй.

2. Аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч (И.Доржсүрэн)-д ДААЛГАХ нь:

2.1 Аймгийн Хүүхэд хамгааллын бодлогын зорилт тус бүрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан жилийн ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, хариуцлагын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах;

2.2 Аймаг, сумын “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хийсэн ажлыг олон нийтэд тайлагнах;

2.3 Аймгийн болон сумын ИТХ-аар хэлэлцэж батлах төсөвт хүүхэд хамгааллын бодлогын арга хэмжээнд болон “Хүүхдийн төлөө зөвлөл”, “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг нэмэлтээр тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

3. Аймгийн хүүхэд хамгааллын бодлогыг өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналт шинжилгээ хийх, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэн, хэрэгжилтийг хангуулах талаар арга хэмжээ авч ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

4. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага бүр өмчийн хэлбэр харгалзахгүйгээр “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл”-ийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийг үндэслэн Хүүхэд хамгааллын бодлого батлан хэрэгжүүлэх, эцэг, эхийн зөвлөл байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоолын 4-т заасан заалтыг хэрэгжүүлж ажиллахад нь аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийтийн эзэмшлийн зам, талбай, гэрээс гадуурх орчинд хүүхдэд эрсдэл учруулж болохуйц

нөхцөл байдлыг (цахилгааны утас, ухсан нүх, гуу жалга, нурсан барилга, балгас, эзэнгүй нохой, харанхуй туулах зай г.м) дахин тогтоож, холбогдох байгууллагуудтай хамтран зөвлөмж

боловсруулан хүргүүлж, анхааруулах арга хэмжээ авч, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллахыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт үүрэг болгосугай.

6. Эмэгтэй төлөөлөгчдийн форумын оролцогчдоос гарсан саналыг агуулгаар нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлж, санал шүүмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийн талаар эргэн танилцуулахыг аймгийн ИТХ-ын Ажлын алба (С.Ундрах)-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the Mongolian coat of arms in the center, with vertical text on the left and right sides, and horizontal text at the top and bottom. The text is in Mongolian script.

О.ПҮРЭВДОРЖ